



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 223

Улаанбаатар хот

Журам, жагсаалт батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь заалтыг үндэслэн
ТУШААХ нь:

1. "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам"-ыг нэгдүгээр, "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт"-ыг хоёрдугаар, хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тушаалыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, 2014 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөн ажиллахыг төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Төлбөртэй тусламж, үйлчилгээний журмын талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр ханган ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Я.Буянжаргал/-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /А.Эрдэнэтуяа/-д даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан "Төлбөртэй үзүүлэх тусламж үйлчилгээний жагсаалт, журам батлах тухай" Эрүүл мэндийн сайдын 2006 оны 277 дугаар тушаал, "Тушаалын заалтад өөрчлөлт оруулах тухай" Эрүүл мэндийн сайдын 2010 оны 193 дугаар тушаал, "Тушаалд нэмэлт оруулах, заалт хүчингүй болгох тухай" Эрүүл мэндийн сайдын 2010 оны 32 дугаар тушаалуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Н.УДВАЛ

D:\barimt\tushaal

081737

ТӨРИЙН ӨМЧИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГААС ҮЗҮҮЛЭХ ТӨЛБӨРТЭЙ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмаар төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас иргэнд үзүүлж буй эрүүл мэндийн зарим тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлэхтэй холбогдох харилцааг зохицуулна.
- 1.2 Төлбөртэй тусламж, үйлчилгээ гэдэгт энэхүү тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан тусламж, үйлчилгээ хамаарах бөгөөд иргэд эдгээр тусламж, үйлчилгээг авахдаа төлбөр төлнө.
- 1.3 Төлбөртэй тусламж, үйлчилгээг төрийн өмчийн клиник, амаржих газар, нэгдсэн эмнэлэг, сувилал, түргэн тусламжийн төв, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, төв эмнэлэг болон тусгай мэргэжлийн төвүүд үзүүлнэ.
- 1.4 Амаржих газар нь төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалтын зөвхөн 3.7, 6.13, 6.15-т заасан тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлнэ.
- 1.5 Түргэн тусламжийн төв нь төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалтын зөвхөн 6.11, 6.12-т заасан тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлнэ.
- 1.6 Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв нь төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалтын зөвхөн 6.16-т заасан тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлнэ.

Хоёр. Төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөр төлөх

- 2.1 Төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалтын 1, 2, 3.2, 3.3, 4 дэх хэсэгт заасан тусламж, үйлчилгээний төлбөрийг Эрүүл мэндийн даатгал /цаашид "ЭМД"/ -д даатгуулсан иргэн нь ЭМД-ын сангаас хөнгөлөлт эдлэн, хөнгөлөгдөөгүй үлдсэн хэсгийг, ЭМД-д даатгуулаагүй иргэн өөрөө бүрэн төлнө.
- 2.2 Төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалтын 3.1, 3.4-3.7 болон 5, 6 дахь хэсэгт заасан тусламж, үйлчилгээний төлбөрийг иргэн өөрөө бүрэн төлнө.
- 2.3 "Эрүүл мэндийн тухай" хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6-д заасан тусламж, үйлчилгээ буюу "Төлбөрийг нь төр хариуцах тусламж, үйлчилгээ"-г авч буй иргэнээс төлбөр авахгүй.
- 2.4 Нийгмийн халамжид хамрагдагсад хавсралтаар батлагдсан жагсаалтын 1-д заасан үндсэн оношилгоо шинжилгээг төлбөргүй үзүүлэх ба энэхүү тусламж, үйлчилгээний зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.
- 2.5 Иргэн төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийг тусламж, үйлчилгээ үзүүлсэн эмч, эрүүл мэндийн ажилтантай хийхгүй, зөвхөн төлбөр хураах төвлөрсөн цэгт төлж, төлбөр төлснийг нь нотлох баримт авна.

Гурав. Төлбөртэй тусламж, үйлчилгээний орлогыг бүртгэх, төсөвт тусгах ажиллагаа

- 3.1 Төлбөртэй тусламж, үйлчилгээнээс олсон орлого нь тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогод бүртгэгдэнэ.
- 3.2 Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага нь төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийг хураах үйл ажиллагааг иргэнд ойлгомжтой, хүндрэл чирэгдэлгүй байдлаар нэг цэгт төвлөрүүлэн зохион байгуулна.
- 3.3 Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага нь төлбөртэй тусламж, үйлчилгээнээс олсон орлогыг байгууллагын цахим бүртгэлийн програм, санхүүгийн програм зэргийг ашиглан, төрийн сан дахь байгууллагын төсвийн харилцах дансанд төвлөрүүлнэ.
- 3.4 Цахим бүртгэлийн програм хангамжгүй төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага нь стандарт, хэмжил зүйн байгууллагаар баталгаажуулсан кассын машин ашиглаж, төлбөрийг хураана.
- 3.5 Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага нь иргэнд төлбөр төлсөн баримтыг заавал олгох бөгөөд уг баримтанд эрүүл мэндийн байгууллагын нэр, эмчийн нэр, иргэнд үзүүлсэн тусламж, үйлчилгээний нэр, төрөл, төлбөл зохих нийт болон үйлчилгээ нэг бүрийн төлбөрийн хэмжээ, үүнээс эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх төлбөрийн хэмжээ, хувь хүний төлсөн төлбөрийн хэмжээ, огноог тэмдэглэсэн байна.
- 3.6 Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага нь төлбөртэй тусламж, үйлчилгээнээс олох орлого болон зарцуулах зардлыг тооцож, жил бүрийн төсвийн төсөлд тусгана.

Дөрөв. Төлбөртэй тусламж, үйлчилгээний талаарх мэдээлэл

- 4.1 Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага нь иргэдэд зөвлөгөө өгөх нээлттэй мэдээллийн цэгийг (лавлах)-ийг төлбөр хураах нэг цэгийн ойролцоо ажиллуулна.
- 4.2 Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага нь төлбөртэй тусламж, үйлчилгээтэй холбоотой дараах мэдээллийг мэдээллийн самбар, үйлчлүүлэгчийн хүлээлгийн танхим болон төлбөр хураах нэг цэгийн дэргэд иргэнд харагдахуйц, ойлгомжтой байдлаар байршуулах ба байгууллагын вэбсайтад байрлуулна. Үүнд:
 - 4.2.1 Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам, жагсаалт
 - 4.2.2 Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ /Хэрэв тухайн эрүүл мэндийн байгууллага өөрийн байгууллагын үзүүлж буй тусламж үйлчилгээний төлбөрийн хэмжээг жишиг хэмжээнээс доогуур баталсан бол тухайн төлбөрийн хэмжээ/
 - 4.2.3 ЭМД-ын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний оношийн бүлгээрх жагсаалт, оношийн бүлэг тус бүрт даатгалын сангаас олгож буй санхүүжилтийн хэмжээ, даатгуулагчийн төлөх хамтын төлбөрийн хэмжээ

Тав. Бусад

- 5.1 Иргэн өөрийн хүсэлтээр төлбөртэй тусламж, үйлчилгээг зогсоох санал гаргавал тухайн тусламж, үйлчилгээг зогсоох хүртэлх үеийн төлбөрийг тооцож, үлдэгдэл төлбөрийг ямар нэгэн шимтгэл, хураамжгүйгээр буцаан олгож, баримтжуулна.
- 5.2 Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлж буй хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний зардалд тухайн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх үед хийгдсэн үндсэн оношилгоо шинжилгээ, эмчилгээ, бариа засал, нөхөн сэргээх эмчилгээ, сувилахуйн тусламж, үйлчилгээ багтах бөгөөд энэхүү зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас болон иргэнээс давхардуулан авахгүй.
- 5.3 Төлбөртэй өрөөгөөр үйлчлэх тусламж, үйлчилгээг зөвхөн иргэний хүсэлтээр эрүүл мэндийн бус, нэмэлт үйлчилгээ үзүүлэх зорилгоор явуулна. Төлбөртэй өрөөнд хэвтэн эмчлүүлснээр иргэн бусад ижил төрлийн тусламж, үйлчилгээ авч буй иргэнээс илүү эмчилгээ, оношилгоо, сувилгаа авах, хөнгөлөлт эдлэх үндэслэл болохгүй.
- 5.4 Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага нь иргэдээс жагсаалтад зааснаас бусад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон анхан шатны маягт, бие засах газар, нөмрөг, улавч, машины зогсоол, халатны үнэ, өвчтөн шилжүүлэх болон шинжилгээний бичиг олгох, хувцас өлгөх гэх зэрэг нийтлэг үйлчилгээнээс төлбөр авахгүй.
- 5.5 Иргэн эрүүл мэндийн байгууллагын төлбөртэй тусламж, үйлчилгээтэй холбоотой асуудлаар тухайн эрүүл мэндийн байгууллагын удирдлага, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн яам болон бусад холбогдох байгууллагуудад гомдол гаргах эрхтэй.
- 5.6 Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага энэхүү тушаалыг зөрчиж, төлбөр авсныг эрх бүхий этгээд нотолсон тохиолдолд эрүүл мэндийн байгууллага иргэний төлбөрийг буцаан олгож, хохирлыг барагдуулна.

150
Эрүүл мэндийн сайдын 2014 оны
07 сарын 04 өдрийн 223 дугаар
тушаалын 2 дугаар хавсралт

ТӨРИЙН ӨМЧИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН
ТӨЛБӨРТЭЙ ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ


1. Үндсэн оношилгоо, шинжилгээ

- 1.1. Зүрхний үйл онош
- 1.2. Мэдрэлийн үйл онош
- 1.3. Уушгины үйл онош
- 1.4. Чих, хамар хоолой, дуу авиан оношилгоо
- 1.5. Эхосонографийн оношилгоо
- 1.6. Рентген оношилгоо
- 1.7. Рентген болон флюор зураг авалт
- 1.8. Тархины судас доплерографи
- 1.9. Тархины цахилгаан бичлэг
- 1.10. Тархины судсан дотуурх оношилгоо
- 1.11. Клиник химийн шинжилгээ
- 1.12. Биохимийн шинжилгээ
- 1.13. Нян судлалын шинжилгээ
- 1.14. Цусны бүлэгнэлтийн шинжилгээ
- 1.15. Гематологийн шинжилгээ
- 1.16. Дархлаа тодорхойлох шинжилгээ
- 1.17. Эд, эсийн шинжилгээ
- 1.18. Вирусын шинжилгээ
- 1.19. Дааврын шинжилгээ
- 1.20. Маркерийн шинжилгээ
- 1.21. Иммуногематологийн шинжилгээ
- 1.22. Харшлын сорилын шинжилгээ
- 1.23. Нүдний уг дурандах оношилгоо

2. Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ

- 2.1. Цөмийн оношилгоо
- 2.2. Дурангийн оношилгоо, шинжилгээ
- 2.3. MRI-н оношилгоо
- 2.4. Компьютер томографын оношилгоо
- 2.5. Маммографийн оношилгоо
- 2.6. Ангиографийн оношилгоо
- 2.7. Миографийн шинжилгээ
- 2.8. ERCP цөс, нойр булчирхайн замыг тодосгон шинжлэх

- 2.9. Молекул биологийн шинжилгээ /В, С вирус тоолох, нуклейн хүчил тодорхойлох/
- 2.10. Эдийн тохироо үзэх шинжилгээ
- 2.11. Эмийн тун тодорхойлох шинжилгээ



3. Амбулаторийн эмчилгээ

- 3.1. Цөмийн эмчилгээ
- 3.2. Амбулаториор хийгдэх уламжлалт эмчилгээ, бариа засал, нөхөн сэргээх эмчилгээ, сувилахуйн тусламж, үйлчилгээ
- 3.3. Насанд хүрэгчдийн шүдний эмчилгээ, протез, гажиг засал
- 3.4. Нүдний хараа заслын лазерын эмчилгээ
- 3.5. Гоо заслын эмчилгээ
- 3.6. Сайн дурын вакцинжуулалт
- 3.7. Иргэний хүсэлтээр хийгдэж буй үр хөндөлт

4. Эмнэлгийн хэрэгсэл


- 4.1. Мэс засалд хэрэглэгдэх хиймэл үе, холбоос, нөхөөс, метал бэхлэгч, судасны хавчаар, пейсмейкер, цус тогтоогч болон хиймэл яс, шөрмөс, судас;
- 4.2. Ангиограф, томограф, маммограф, MRI-н оношилгоо, эмчилгээнд хэрэглэгдэх тодотгогч бодис, зонд;
- 4.3. Дурангийн мэс заслын эмчилгээнд хэрэглэгдэх нэг удаагийн цоолтуур, хавчаар, эрхтэн оёх, таслах багаж;
- 4.4. Гэрээний үндсэн дээр гадны эмнэлгээс хийгдэж буй хос катетр тавилт

5. Эрхтэн шилжүүлэх тусламж үйлчилгээ

- 5.1. Элэг шилжүүлэн суулгах мэс засал
- 5.2. Бөөр шилжүүлэн суулгах мэс засал
- 5.3. Чөмөг шилжүүлэн суулгах мэс засал
- 5.4. Үе шилжүүлэн суулгах мэс засал
- 5.5. Нүдний эвэрлэг шилжүүлэн суулгах мэс засал
- 5.6. Арьс нөхөх, шилжүүлэн суулгах мэс засал
- 5.7. Цусны үүдэл эс шилжүүлэн суулгах

6. Бусад

- 6.1. Үргүйдлийн тусламж, үйлчилгээ
- 6.2. Нөхөн сэргээх мэс заслын тусламж, үйлчилгээ
- 6.3. Иргэн өөрийн хүсэлтээр төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд шатлал алгассан тусламж, үйлчилгээ авсны төлбөр
- 6.4. Эрүүл мэндийн салбарт шинээр нэвтрүүлж буй монголд эмчлэгдэхгүй байгаа өвчин эмгэгийн оношилгоо, эмчилгээ
- 6.5. ЭМД-д даатгуулаагүй иргэний ЭМД-аас санхүүждэг бүх төрлийн оношилгоо, эмчилгээ
- 6.6. Донтолт, архидалтаас үүссэн гэмтэл, хордлогын оношилгоо, эмчилгээ;
- 6.7. Аж, ахуй нэгж байгууллагатай гэрээгээр гүйцэтгэх урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо

- 
- 6.8. Иргэн санаатайгаар амь насаа бусниулахаар оролдсон тохиолдлын оношилгоо, эмчилгээ
- 6.9. Эрүүл мэндийн даатгалд даатгуулаагүй гадаадын иргэн, харьяалалгүй хүмүүст үзүүлсэн бүх төрлийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ
- 6.10. Ажил сургуульд орох, жолооны үнэмлэх авах болон гадаадад явахад шаардагдах эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ
- 6.11. Төрийн тусгай хамгаалалт, олон улсын томоохон хурал зөвлөгөөнөөс бусад төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулж буй арга хэмжээний үед бэлэн байдлыг хангах үүднээс хүсэлт гарган авах эмч, түргэн тусламжийн үйлчилгээ
- 6.12. Архаг хууч өвчний улмаас өрхийн эмчийн хяналтад эмчлүүлж байгаад гэртээ нас барсан тохиолдолд ар гэрийнхний гаргасан хүсэлтийн дагуу шарилыг цогцос хадгалах газар хүртэл тээвэрлэх үйлчилгээ
- 6.13. Иргэний ЭМД-ын тухай хуулийн 12.5 заалтын дагуу даатгуулагчийн төлөх хамтын төлбөр
- 6.14. Ажлын бус цагаар иргэний хүсэлтээр хийж буй гэрийн асаргаа сувилгаа, гэрийн болон эмнэлгийн дуудлага /103 дуудлагаас бусад/
- 6.15. Эмнэлгийн төлбөртэй өрөөний үйлчилгээ /Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагын нэг тасаг нэгжид байх төлбөртэй өрөөний дээд хязгаар нь тухайн тасгийн нийт орны 10 хувь байна. /
- 6.16. Орчин хүнстэй холбогдох шинжилгээ, дүгнэлт
- 6.17. Шарил хадгалах үйлчилгээ /эмнэлгийн нас баралтаас бусад/
- 6.18. Хувийн эмнэлгийн хүсэлтээр хийлгэх эмгэг судлалын задлан шинжилгээ
- 6.19. Иргэний болон хувийн эмнэлгийн хүсэлтээр хийлгэх иммуногистохимийн шинжилгээ